Өвөрхангай
Эрүүл Мэндийн Газар




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал




*М.Золзаяа, ЭМГ-ын НЭМХ-ийн дарга, НЭМУ-ын магистр*




# Агуулга




***Агуулга***

- Удирдлага, зохион байгуулалт
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал
- Тулгамдаж буй асуудал
- 2024 онд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ




# “Алсын хараа-2050” Эрүүл мэнд




***Зорилт 2.2.Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.***

**Салбарын хөгжлийн зорилго:**

| | | |
|---|---|---|
| 1-р үе шат | 2021-2030 он | Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй тогтолцооны шинэчлэлийн үе |
| 2-р үе шат | 2031-2040 он | Амьдралын зөв дадал, хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх үе |
| 3-р үе шат | 2041-2050 он | Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих үе |




# *Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр*






МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар сарын 9-ний өдөр | Улаанбаатар хот

Дугаар 203

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16.3, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 1 дүгээр хавсралт, "Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээг жил бүрийн улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн хүрээний мэдэгдэл, жил бүрийн улс, орон нутгийн төсвийн төсөлд тусган хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан) нарт даалгасугай.

3. Эрхлэх асуудлын хүрээнд болон харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын сайд,

Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга Л.ОЮУН-ЭРДЭНЭ

2.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

2.1.5.1. Төрөлжсөн мэргэшлийн төв болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийг дэмжих төв байгуулах




# *Нийгмийн эрүүл мэнд Хүний нөөц*




**НЭМХ**
**10 мэргэжилтэн**

ЭМГ

БОЭТ

Эрүүл мэндийг дэмжих төв -7

Нийгмийн эрүүл мэндийн судлаач, ажилтан-4

Хархорин

Эрүүл мэндийг дэмжих төв
Нийгмийн эрүүл мэнд, дэмжих, тандалт , судалгааны алба -13

Сумдын ЭМТ

Нийгмийн эрүүл мэндийн ажилтан-18, бүгд ажил хавсардаг

Өрхийн ЭМТ

Нийгмийн эрүүл мэндийн ажилтан-4




# Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн одоогийн бүтэц, бүрэлдэхүүн




**Хэлтсийн дарга**

1.Нийгмийн эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт, 2.Төсөл хөтөлбөрийн зохицуулалт, 3.Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалт сэргийлэлтийн асуудал, 4.Хөдөлмөрийн аюулгүй байдал

**Ахлах мэргэжилтэн-1**

1. Өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэнд
2. Оюутан, цэргийн насны залуучууд,
3. Жендэр, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудал

**Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн-2**

1.Бэлгийн замаар дамжих халдвар, дархлалын олдмол хомсдол, 2.Вируст гепатитийн болон 3.Гэдэсний халдварын халдварын тандалт, сэргийлэлт

1.Амьсгалын замын халдвар, сүрьеэ, 2.Зоонозын халдварын тандалт, сэргийлэлт

Халдварт өвчин, дархлаажуулалтын мэдээ, мэдээлэл, хүйтэн хэлхээ хариуцсан ажилтан -1

**Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн -2**

1.Халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг, тандалт, сэргийлэлт, 2. Осол гэмтэл, хүчирхийлэл, 3. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудал

1. Халдварт бус өвчин, нийтийн биеийн тамир 2Архи тамхины хэрэглээг бууруулах, 3.хүн амын зохистой хооллолтын асуудал

**Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн-1**

1.Орчны эрүүл мэнд
2. уур амьсгалын өөрчлөлт
3.Химийн бодисын аюулгүй байдал
4.Хүнсний аюулгүй байдал

**Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн-1**

1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал

2.ахмад настны эрүүл мэнд, 3.лаборатори

**Эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн-1**

1.Эрүүл мэндийн дэмжих,

2.Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл, сургалт, сурталчилгаа




# *Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал*

# Халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлийн тархалт






**Архины хэрэглээ**

26.1%/34.8%

**Тамхины хэрэглээ**

**19.6%/24.2%**



Жимс, жимсгэнэ

**54.9/87.9**



**Хүнсний ногоо-23.4%/87.9%**




**95.1%/92.5%**



Таргалалт-19.3,/53.5%

Давсны хэрэглээ **11.4%/10.6%**

Идэвхтэй дасгал хөдөлгөөн

72.8%/42.8%





Монгол улсад хийгдсэн 2019 оны STEPS судалгаагаар хагай бүсэд 15-64 насны хүн амын 3 хүн тутмын 1 нь архи хэрэглэдэг, 4 хүн тутмын 1 нь тамхи хэрэглэдэг, 2 хүн тутмын 1 нь дасгал хөдөлгөөн хийдэггүй, таргалалттай, давсны хэрэглээ стандартад заасан хэмжээнээс 2 дахин өндөр үр дүн гарсан.

Эх, сурвалж: Халдварт бус өвчний STEPS судалгааны үр дүн 2013 он, 2019 он




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

# Зонхилон тохиолдож буй халдварт бус өвчлөл, нас баралт




## Зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, (2014-2023 он)




| | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өвөрхангай | 24.3 | 24.5 | 25.6 | 21.5 | 26.2 | 20.1 | 18.1 | 22.6 | 21.6 | 21.7 |

***2023 онд зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралтын түвшин 10 000 хүн амд 21.7 ногдож сүүлийн 10 жилийн дунджаас 2.6 пунктээр буурсан байна.***

## Зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралт 10 000 хүн амд, хүйсээр, (2014-2023 он)




***2023 онд зүрх судасны тогтолцооны шалтгаант нас баралтын түвшин 10 000 эрэгтэй хүн амд 27.5, 10 000 эмэгтэй хүн амд 15.9 ногдож байна.***

***10 жилийн дунджаар 10 000 эрэгтэйд 27.4, эмэгтэйд 20.1 ногдож байна.***




# *Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал*




## Хорт хавдар



| | 2010 он | 2023 он |
|---|---|---|
| **Шинэ тохиолдол** *100,000 хүн амд* | 161.7/**107.1** | **219.5** |
| **Нас баралт** *10,000 хүн амд* | 12.4/**9.4** | **12.8**/**10.6** |



***44.8% нь хожуу үедээ оношлогдож байна.***

***Оношлогдсоноос хойш 61%/96.8 нь 5 жилийн дотор НАС БАРДАГ***




## *Нийгмийн эрүүл мэндийн тусламж үй чилгээний өнөөгийн байдал*




## Хорт хавдрын шалтгаант нас баралты түвшин, 10000 хүнд амд, (2014-2023 он




***Хавдраас шалтгаалсан нас баралт нь халдварт бус өвчний нас баралтын 2-рт, 2023 онд 10000 хүн амд 10.7 байгаа нь улсын дунджаас 1.5 пунктээр доогуур түвшинд байна.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал




## Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин, 10000 хүнд амд, (2014-2023 он)

### *Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралт, 10 000 хүнд амд, хүйсээр, 2013-2023 он*




***2023 онд элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын 59 тохиолдол бүртгэгдэж, нийт хорт хавдрын нас баралтын 40.7 хувийг, 10 000 хүн амд ноогдох нас баралтын түвшин 4.0 байгаа нь сүүлийн 10 жилийн дундажаас 0.9 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.***

### *Уушигны хорт хавдрын нас баралт, 10 000 хүнд амд, 2018-2023 он*




***2023 оны жилийн эцсийн байдлаар уушигны хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 0.6 байгаа нь 5 жилийн өмнөхтэй ойролцоо түвшинд байгаа буюу туруштай буурахгүй байна.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал




## Осол гэмтэл (2018-2023 он)

### Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын түвшин (10000 хүн амд)




### Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан






# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

# Осол гэмтэл 2014-2023 он




## Зам тээврийн ослын шалтгаант нас баралт, 10 000 хүн амд, 2014-2023 он




Сүүлийн 10 жилийн дунджаар зам тээврийн шалтгаант нас баралт 85.2 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

## Амиа хорлолт, 10 000 хүн амд, 2013-2023 он







2023 онд амиа хорлолтын 19 тохиолдол бүртгэгдсэн ба хүйсээр авч үзвэл: 2013-2023 оны дунджаар амиа хорлогчдын 88.2 хувь нь эрэгтэйчүүд байна.




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Нөхөн үржихүйн эрүүл мэнд




### Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэдэг нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь (2020-2023 он)




***Улс, аймгийн түвшнээс 6.2-6.7, эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн зорилтот шалгуур үзүүлэлтээс 0.4 хувиар дээгүүр түвшинд хүрсэн.***

### Нөхөн үржихүйн насны хүн амын урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралт (2022 он-2023 он)




***Эрэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт бага, өвчлөлийн эрүүлжүүлэлтэд ахиц гарч байна.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

# Нөхөн үржихүйн эрүүл мэнд




**15-49 насны эрэгтэйчүүдийн халдварт бус өвчлөлийн тэргүүлэх шалтгаан (2019 он-2023 он)**




**15-49 насны эмэгтэйчүүдийн халдварт бус өвчлөлийн тэргүүлэх шалтгаан (2019 он-2023 он)**




**Эрэгтэйчүүдэд хоол боловсруулах, эмэгтэйчүүдэд шээс бэлгийн эрхтэн тогтолцооны өвчлөл тэргүүлж байна.**

**15-49 насны эрэгтэйчүүдийн халдварт бус өвчний нас баралтын тэргүүлэх шалтгаан (2019 он-2023 он)**




**15-49 насны эмэгтэйчүүдийн халдварт бус өвчний нас баралтын тэргүүлэх шалтгаан (2019 он-2023 он)**




**Эрэгтэйчүүдэд осол гэмтэл, гадны шалтгаант, эмэгтэйчүүдэд зүрх судасны эрхтэн тогтолцооны нас баралт тэргүүлж байна.**




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал




## Нөхөн үржихүйн эрүүл мэнд

### Өсвөр насны хөвгүүдийн дундах өвчлөлийн тэргүүлэх шалтгаан (2019 он-2023он)




### Өсвөр насны охидын дундах өвчлөлийн тэргүүлэх шалтгаан (2019 он-2023 он)




**Өсвөр насны охид хөвгүүдийн дунд хоол боловсруулах, амьсгал, арьс, харшлын өвчлөл тэргүүлж байна.**

### Өсвөр насны хөвгүүдийн дундах нас баралтын тэргүүлэх шалтгаан (2019 он-2023 он)




### Өсвөр насны охидын дундах нас баралтын тэргүүлэх шалтгаан (2019 он-2023 он)




**Өсвөр насны охид хөвгүүдийн дунд осол, гэмтэл, гадны шалтгаант нас баралт тэргүүлж байна.**




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал




## 20 хүртэлх насны охидын төрөлт, үр хөндөлт

| Он | Нийт Төрөлт | 20 хүртэлх насны төрөлт | 20-оос доош насны төрөлтийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Өвөрхангай | Улсын дундаж | Аймгуудын дундаж |
| **2018** | 2404 | 160 | 6.7 | 5.1 | 4.7 |
| **2019** | 2586 | 153 | 5.9 | 4.7 | 4.4 |
| **2020** | 2421 | 109 | 4.5 | 4.3 | 3.9 |
| **2021** | 2202 | 112 | 5 | 5.5 | 4.1 |
| **2022** | 1989 | 73 | 3.7 | 3.7 | 4.1 |
| **2023** | **1960** | **78** | **4.0** | **3.3** | **3.6** |

***Сүүлийн жилүүдэд 20-оос доош насны төрөлт буурч байгаа боловч улс, аймгуудын дундажаас 0.4-0.7 хувиар өндөр байна.***

| | Нийт үр хөндөлт | 20 хүртэлх насны үр хөндөлт | 20-оос доош насны үр хөндөлтийн эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Өвөрхангай | Улсын дундаж | Аймгуудын дундаж |
| **2018** | 168 | 19 | 11.3 | 5 | 7 |
| **2019** | 167 | 14 | 8.4 | 5 | 5.9 |
| **2020** | 166 | 18 | 10.8 | 4.8 | 7.2 |
| **2021** | 171 | 22 | 12.9 | 5.4 | 7.3 |
| **2022** | 167 | 22 | 13.2 | 4.8 | 6.3 |
| **2023** | **164** | **9** | **5.5** | **5.0** | **6.2** |

***Сүүлийн жилүүдэд 20-оос доош насны үр хөндөлт буурч, улсын дундажаас 0.5 хувиар өндөр, аймгуудын дундажаас 0.7 хувиар доогуур байна.***




# *Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал*

## Ахмад настны эрүүл мэнд




### *Хяналтанд байгаа ахмад настан*

**2019 онд**
**11228**

**2020 онд**
**11443**

**2021 онд**
**12006**

**2022 онд**
**12343**

**2023 онд**
**13343**

2023 онд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 16011 ахмад үзлэгт хамрагдсан ба 1911 ахмадыг шинээр хяналтад авч, 544 ахмад шилжиж, 368 ахмад нас барж, тайлант оны эцэст 13343 ахмад настан хяналтад байна.

Хяналтад байгаа ахмадын 824 буюу 6.2 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй, 269 буюу 2 хувь нь насны доройтолтой байна. Нийт хяналтын ахмадаас 11265 буюу 84.4 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.




# *Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал*




## Ахмад настны эрүүл мэнд

### *Хяналтын настны өвчлөлийн байдал /10000 хүнд амд /*




### *Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн ахмадын өвчлөлийн шалтгаан*

**Арвайхээр суманд өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгчдийн дунд зүрх судас, хоол боловсруулах, шээс бэлгийн тогтолцооны өвчин**

**Хувийн хэвшлийн эмнэлгүүдээр үйлчлүүлэгчдийн дунд мэдрэл, зүрх судас, шээс бэлгийн тогтолцооны өвчин**

**Бүсийн оношилгоо эмчилгээний төвд зүрх судас, хоол боловсруулах тогтолцооны өвчин, нүд ба дайврын өвчин**

***Хяналтад байгаа ахмадуудын дунд сүүлийн 3 жилд зүрх судас, хоол боловсруулах, шээс бэлгийн, яс булчингийн эрхтэн тогтолцооны эмгэгүүд тотмол тэргүүлж байна.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Ахмад настны эрүүл мэнд




### Ахмад настанд “Мобайл технологи”-ийг ашиглан үзүүлсэн тусламж үйлчилгээний үр дүн

*Нийт хамрагдсан - 4600*

*Лабораторийн шинжилгээнд - 5166*

*Багажийн шинжилгээнд - 1585*

Хяналтад авсан – 464

Дээд шатлалд илгээсэн- 384

Нийгмийн халамж дэмжлэгт хамруулсан-186

*Сэргээн засах, хөнгөвчлөх, гэрийн сувилахуйн тусламж үйлчилгээнд хамруулсан - 4068*

*ЭММСС-3812*

*Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэлд- 1040*












# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Зонхилон тохиолдож буй халдварт өвчин




### Амьсгалын замаар дамжих халдвар, 10000 хүн амд




### Амьсгалын замаар дамжих халдвар сумдаар,10000 хүн амд





# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Зонхилон тохиолдож буй халдварт өвчин




## Томуу, томуу төст өвчин, 2020-2024

- Улирал хооронд
- Идэвхжлийн түвшин
- Алаг цоог
- Аймгийн түвшний дэгдэлт
- Тахал тархалт







***2023-2024 оны томуугийн жилд томуу, томуу төст өвчлөлийн тархалт улирал хооронд 13, идэвхжлийн үе 34, алаг цоог дэгдэлт 18, аймгийн хэмжээний дэгдэлтийн түвшинд 1 удаа хүрсэн байна. 2024 оны 18-р долоо хоногийн байдлаар ТТӨ 10000 хүн амд 37.8, АЗЦХХ 2.9 ноогдож ИДЭВХЖЛИЙН ТҮВШИНД байна.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

# Зонхилон тохиолдож буй халдварт өвчин




## Бэлгийн замаар дамжих халдвар, 10000 хүн амд




## Бэлгийн замаар дамжих халдвар сумдаар, 10000 хүн амд




***2023 оны жилийн эцсийн байдлаар бүртгэгдсэн БЗДХ өвчнийг 10000 хүн амд харьцуулахад 6 сум буюу 31.5 хувь нь улсын дунджаас, 13 сум буюу 68.4 хувь нь аймгийн дундаж үзүүлэлтээс тус тус өндөр байна.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Сүрьеэгийн өвчлөл, 2019-2023 он


















# Заавал хийх товлолт дархлаажуулалтын хамралт, 2022, 2023 он, улсын дундажтай харьцуулсан үзүүлэлт







*Заавал хийх дархлаажуулалтын 2023 оны хамралтыг өмнөх оны түвшинтэй харьцуулахад гепатит А вирусын эсрэг вакцины 1-р тун 0.1, сахуу, татрангийн вакцины 2-р тунгийн хамралт өмнөх оноос 2.1 хувиар тус тус нэмэгдсэн, сүрьеэ, гепатит В вирусын эсрэг вакцин, халдварт саагийн вакцины 4-р тунгийн хамралт өмнөх оны түвшинд бусад вакцинуудын хамралт 0.3-1.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.*




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

# Зоонозын халдварт өвчин




| Тарваган тахлын голомттой | Боомын голомттой | Галзуу өвчний голомттой | Хачигт халдварын голомттой |
|---|---|---|---|
| • Хайрхандулаан<br>• Уянга<br>• Нарийнтээл<br>• Тарагт<br>• ЗБУ<br>• Арвайхээр | • Хархорин<br>• Хужирт<br>• ЗБУ<br>• Уянга<br>• Тарагт<br>• Есөнзүйл | • Бүх сумд | • Бүх сумд |

- Голомтот нутгийн болон эрсдэлт бүлгийн хүн амыг тарваган тахал, боом, хачигт халдвар, галзуу, шар чичрэг, хумхаагаас сэргийлэх вакцинд 90-ээс доошгүй хувийг хамруулсан.
- Зоонозын халдварын эрсдэлд өртсөн тохиолдолд галзуу, хачигт халдвар, боом өвчний эсрэг иммуноглобулиныг хийж халдвараас урьдчилан сэргийлсэн.

### Тарваган тахал

- Сум: 5-8
- Талбай: 117000 га
- Тандалтын тоо: 31
- Сорьцын тоо: 1425

### Хачгийн тандалт



- Сум: 5-8
- Талбай: 54000 га
- Тандалтын тоо: 45
- Сорьцын тоо: 837

### Шумуулийн тандалт



- Сум: 1
- Талбай: 54000 га
- Тандалтын тоо: 14
- Сорьцын тоо: 58

### Шувууны тандалт



- Сум: 4-8
- Талбай: 45000 га 13 нуур
- Тандалтын тоо: 46
- Сорьцын тоо: 46

### Боом, Холер



- Сум: 8-12
- Аж ахуйн нэгж : 102
- Тандалтын тоо: 38
- Сорьцын тоо: 865
- Өсгөвөр: 2

- **19 сум 86 баг**
- **Хамруулсан талбай: 315000 га, 5245 цэгт газар**
- **Тандалтын тоо: 174**
- **Сорьцын тоо: 3231**




**Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал**

**Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал**




# Гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн албаны зохион байгуулалт




***Тохиолдлын удирдлагын тогтолцооны гишүүд болон 2 мэргэжлийн ангийн нийт 125 хүний томилгоот бүрэлдэхүүнтэй.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал




2023 оны 12-р сарын 31-ний байдлаар Өвөрхангай аймгийн зудын эрсдэлийн түвшины индекс **7.1** буюу их түвшинд байсан.

**Аймаг дотроо**

- 228 өрхийн 491 хүн

**Гадны аймагт**

- 168 өрхийн 536 хүн

**Нийт**

- 396 өрх, 1027хүн

## Өвөрхангай аймгийн зудын эрсдэлийн түвшин /сумдаар/




**Цагаан зудтай –** Хайрхандулаан, Богд, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Төгрөг, Хужирт /6 сум/

**Цагаанаар зудархуу -**, Бат-Өлзий, Хархорин, Нарийнтээл, Баянгол, Баян-Өндөр /5 сум/




# *Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал*

# *Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал*




## "Өвөлжилт хүндэрсэн Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх" төсөл хэрэгжүүлсэн.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 24.9 сая төгрөгийн санхүүжилтээр Хархорин, Баянгол, Баян-Өндөр, Есөнзүйл, Өлзийт, Сант зэрэг 6 суманд хэрэгжүүлэн ажилласан.

Нийт 30 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 5-10 хоногийн турш 442 өрхийн 1083 иргэнд 28 мянга гаруй километр замыг туулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж ажилласан байна.

0-2 насны 14 хүүхдийг товлолын дархлаажуулалтад хамруулж, 400 гаруй иргэдийг амин дэм, эрсдийн багцаар хангаж, 200 орчим иргэнд нэн шаардлагатай эмийн багцаар үйлчилсэн байна.

Эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөөг 952 иргэнд хүргэж, 852 ширхэг гарын авлага, тараах материал түгээсэн байна.

### Үзлэт хамрагдсан иргэдийн өвчөлийн байдал




### Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчлөлийн бүтэц






# “Өвөлжилт хүндэрсэн Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэх” төслийн хэрэгжилтийн явц



















# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

# Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал




Эрүүл мэндийн байгууллагуудын 500 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх дадлага, сургалт зохион байгуулав.













## Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал




### Газар хөдлөлтийн гамшгийн үед "Хээрийн эмнэлэг дэлгэх" дадлага сургууль зохион байгуулав.













**Хээрийн эмнэлэгийн дадлага сургуулилтад:**

- 30 ортой, хээрийн эмчнэлгийн **16 объект**
- 125 эмч, эмнэлгийн мэргэжилтэн
- 351 нэр төрлийн тоног төхөөрөмж
- 120 гаруй нэр төрлийн 47 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл яаралтай түргэн тусламжийн 4 автомашин
- Цус, цусан бүтээгдэхүүний 303 нэгж бүтээгдэхүүн
- 168 сая төгрөгийн 37 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэн ажилласан.




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Орчны эрүүл мэнд




## Агаарын чанарын стандарт

| Үзүүлэлтийн нэр | Хэмжилтийн дундаж хугацаа | Хэмжих нэгж | MNS 4585:2016 | ДЭМБ 2005 он | ДЭМБ 2021 он | Өвөрхангай аймаг 2023 он |
|---|---|---|---|---|---|---|
| Хүхэрлэг хий (S02) | 10 минут дундаж | $мкг/м^3$ микрограмм | - | 500 | - | - |
| | 20 минут дундаж | | 450 | - | - | - |
| | 24 цаг дундаж | | 50 | 20 | 40 | - |
| | Жилийн дундаж | | 20 | - | - | **35** |
| Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) | 15 минут дундаж | $мкг/м^3$ | - | - | - | - |
| | 20 минут дундаж | | 60000 | 100000 | - | - |
| | 1 цаг дундаж | | 30000 | 35000 | - | - |
| | 8 цаг дундаж | | 10000 | 10000 | - | - |
| | 24 цаг дундаж | | - | 7000 | 4000 | - |
| Азотын давхар исэл (N02) | 20 минут дундаж | $мкг/м^3$ | 200 | - | - | - |
| | 1 цаг дундаж | | - | 200 | - | - |
| | 24 цаг дундаж | | 50 | - | 25 | - |
| | Жил дундаж | | 40 | 40 | 10 | **46** |
| Озон (03) | 8 цаг дундаж | $мкг/м^3$ | 100 | 100 | 100 | - |
| PM10 тоосонцор | 24 цаг дундаж | $мкг/м^3$ | 100 | 50 | 45 | - |
| | Жил дундаж | | 100 | 20 | 15 | - |
| PM2.5 тоосонцор | 24 цаг дундаж | $мкг/м^3$ | 50 | 25 | 15 | - |
| | Жил дундаж | | 25 | 10 | 5 | **93** |




# *Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал*

# *Орчны эрүүл мэнд*




## *АГААРЫН БОХИРДЛЫН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ ХОР, НӨЛӨӨ*




**PM тоосонцорын бохирдол нь:**

- **Зүрхний шигдээс**
- **Харвалт**
- **Уушгины архаг бөглөрөлтөт өвчин,**
- **Багтраа,**
- **Хорт хавдрын өвчлөлийн**

**шалтгаан болж байна.**




# *Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал*

## *Орчны эрүүл мэнд*




## *Хөрсний дээжийн шинжилгээ 2022 он /хүнд металл/*




***Арвайхээр сумын хэмжээнд 14 цэгт 12 төрлийн хүнд металлыг тодорхойлоход хөрсөн дэх хар тугалгын дундаж агууламж 40.8 мг/кг байгаа нь стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй ч өмнөх оноос ихэссэн, стронцийн агууламж зарим цэгүүдэд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1.1-1.8 дахин их байна.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Орчны эрүүл мэнд




### Сумын эрүүл мэндийн төвүүдийн усан хангамж, ариун цэврийн байгууламж




***Сумын эрүүл мэндийн төвүүдийн 38.8 хувь нь хэсгийн септик системд, 22.2 хувь нь төвийн төвлөрсөн системд холбогдсон 11.1 хувь нь сайжруулсан нүхэн жорлонтой байна.***

### Ундны усны шинжилгээ /нянгийн үзүүлэлтүүд/







***Ундны усан дахь гэдэсний савханцарын тоо зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээж өмнөх оноос 1.1 хувиар буурсан, нянгийн ерөнхий тоо зөвшөөрөглөх дээд хэмжээнээс хэтэрсэн дээж 1.9 хувиар өссөн байна.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

# Лабораторийн тусламж, үйлчилгээ




## Лабораторийн тоног төхөөрөмжийн хангалт

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Сум, өрхийн ЭМТ-ийн нэр | Хангалтын хувь |
|---|---|---|---|
| 1 | Шээсний анализатор /хагас автомат анализатор, тууз уншигч/ | БаруунбаянУлаан, Бат-өлзий, Баян-Өндөр, Баянгол, Богд, Бүрд, Гучин, Сант, Есөнзүйл, ЗүүнбаянУлаан, Нарийнтээл, Өлзийт, Тарагт,Төгрөг, Уянга, Хархорин, ЭнэрэлХархорин, Хайрхандулаан, Хужирт, Уянсэтгэл, Түшигдөлгөөн, Нарны дөш, | 22 нэгж буюу 100 % |
| 2 | Биохимийн анализтор | Баян-Өндөр, Баянгол, Бүрд, Есөнзүйл, ЗүүнбаянУлаан, Нарийнтээл, Өлзийт, Тарагт,Төгрөг, Уянга, Хархорин, Хайрхандулаан, Уянсэтгэл, Түшигдөлгөөн, Нарны дөш, ЭнэрэлХархорин, Бат-өлзий, Богд, Хужирт, Гучин-ус /бүрэн автомат/ | 21 нэгж буюу 95,4 % |
| 3 | Гематологийн анализтор /хагас/ | БаруунбаянУлаан, Бат-өлзий, Баян-Өндөр, Баянгол, Богд, Бүрд, Гучин, Сант, Есөнзүйл, ЗүүнбаянУлаан, Нарийнтээл, Өлзийт, Тарагт,Төгрөг, Уянга, Хархорин, ЭнэрэлХархорин, Хайрхандулаан, Хужирт, Уянсэтгэл, Түшигдөлгөөн, Нарны дөш, | 22 нэгж буюу 100 % |
| 4 | Иммунологийн аппарат | Хархорин, Бат-өлзий, Хужирт, Өлзийт, Баянгол, Түшигдөлгөөн, Уянсэтгэл, Нарны дөш | 8 нэгж буюу 36.4 % |

2023 онд сумдын 66.6 хувь нь лабораторийн аппарат, тоног төхөөрөмжөөр хангагдсан




**Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал**

**Лабораторийн тусламж, үйлчилгээ**




## Хүний нөөцийн мэргэшсэн байдал

| Мэргэжлийн лаборанттай эрүүл мэндийн байгууллагууд | Баримжаа олгох сургалтанд хамрагдсан лаборанттай эрүүл мэндийн байгууллагууд | Мэргэжлийн бус сувилагч, эм зүйч, бага эмч ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллагууд |
|---|---|---|
| Бүсийн оношилгоо эмчилгээний төв | БаруунбаянУлаан | Баянгол |
| Бат-өлзий | Баян-өндөр | Сант |
| Богд | Бүрд | Төгрөг |
| Нарийнтээл | Гучин-ус | Хайрхандулаан |
| Хархорин НЭ | Зүүнбаян-улаан | Есөнзүйл |
| Хужирт | Тарагт | |
| Уянсэтгэл ӨЭМТ | Түшигдөлгөөн | |
| Ачтан-ирээдүй | Нарны дөш | |
| Чинмэнд | ЭнэрэлХархорин | |
| Ариунсанаа | Өлзийт | |
| Уянга | | |
| Сидар мед | | |
| **12 байгууллага** | **10 байгууллага** | **5 байгууллага** |




## Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Лабораторийн тусламж, үйлчилгээ




### Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын хийж буй лабораторийн шинжилгээний нэр төрөл

| № | Биохимийн шинжилгээ | Цусны ерөнхий шинжилгээ | Шээсний ерөнхий шинжилгээ | Иммунологийн шинжилгээ |
|---|---|---|---|---|
| 1 | Бат-өлзий, Баян-Өндөр, Баянгол, Богд, Бүрд, Гучин, Есөнзүйл, ЗүүнбаянУлаан, Нарийнтээл, Өлзийт, Тарагт,Төгрөг, Уянга, Хархорин, Хайрхандулаан, Хужирт, Уянсэтгэл, Түшигдөлгөөн, Нарны дөш, ЭнэрэлХархорин, /БаруунбаянУлаан/ | БаруунбаянУлаан, Бат-өлзий, Баян-Өндөр, Баянгол, Богд, Бүрд, Гучин, Сант, Есөнзүйл, ЗүүнбаянУлаан, Нарийнтээл, Өлзийт, Тарагт,Төгрөг, Уянга, Хархорин, ЭнэрэлХархорин, Хайрхандулаан, Хужирт, Уянсэтгэл, Түшигдөлгөөн, Нарны дөш, | ББУ, Бат-өлзий, Баян-Өндөр, Баянгол, Богд, Бүрд, Гучин, Сант, Есөнзүйл, ЗүүнбаянУлаан, Нарийнтээл, Өлзийт, Тарагт,Төгрөг, Уянга, Хархорин, ЭнэрэлХархорин, Хайрхандулаан, Хужирт, Уянсэтгэл, Түшигдөлгөөн, Нарны дөш, | Хархорин, Бат-өлзий, Хужирт, Өлзийт, Баянгол, Түшигдөлгөөн, Уянсэтгэл, Нарны дөш, |
| **Нийт** | **21 нэгж** | **22 нэгж** | **22 нэгж** | **8 нэгж** |

**2023 онд 7 сумын ЭМТ иммунологи, биохимийн 7 үзүүлэлтийг орон нутагтаа хийдэг болсон**




## Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Лабораторийн тусламж, үйлчилгээ




### Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн нэгдсэн лабораторид шинээр нэвтрүүлсэн шинжилгээний төрөл

- коронавируст халдвар илрүүлэх шинжилгээ -121
- бэлгийн зам халдварын үүсгэгч илрүүлэх шинжилгээ - 171
- хөхөнцөр вирус илрүүлэх шинжилгээ - 71
- С вирусын ачаалал тоолох шинжилгээ - 84
- Томуугийн үүсгэгч тодорхойлох
- В вирусын ачаалал тоолох шинжилгээ - 128
- С вирусын ачаалал тоолох шинжилгээ - 84

Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн бактерологийн лаборатори нь

2023 оны 4 сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Биологийн шингэн (цэр, шээс, бөөлжис, гялтангийн шингэн, хэвлийн шингэн г.м), залгиур хоолойн арчдас, хатиг, буглаа, үрэвслийн шингэнээс бактер өсгөвөрлөх шинжилгээ хийгдэж антибиотик тэсвэрт чанарыг тодорхойлох боломжтой болсон.




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Эрүүл мэндийг дэмжих, МСС




### Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн газрын цахим хуудас




**Нийт 3.3 сая гаруй хүн хандсан**

*Нийт цахим хуудасны дагагчдын тоо сүүлийн 5 жилд 3 дахин буюу 192 хувиар, хуудас таалагдсан тоо 2.5 дахин буюу 158.6 хувиар тус тус өссөн байна.*







**Эр-26.5**
**Эм-73.5**




## Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Эрүүл мэндийг дэмжих, МСС




### Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр ажилласан байгууллага, айл өрх




2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд эрүүл мэндийг дэмжигч 44 байгууллага байна.

Үүнээс 1-р зэрэгтэй 10 байгууллага, 2-р зэрэгтэй 12 байгууллага, 3-р зэрэгтэй 22 байгууллага байна.

Эдгээрээс 8 эрүүл мэндийн байгууллага, 28 боловсролын байгууллага, 2 аж ахуй нэгж, 6 бусад байгуулагууд байна.

Эрүүл мэндийг дэмжигч 70 айл өрх байна. Үүнээс 1-р зэрэгтэй 7 айл өрх, 2-р зэрэгтэй 16 айл өрх, 3-р зэрэгтэй 47 айл өрх байна.

***Эрүүл мэндийг дэмжигч 3 сум, Дасгал хөдөлгөөн, эрүүл хооллолтыг хэвшүүлсэн 25 хамт олон, архи тамхигүй хамт олон 12, эрүүл мэндийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдаж хэвшсэн 44 байгууллага, 100 гаруй айл өрх байна.***




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал

## Эрүүл мэндийг дэмжих, МСС




*Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх, Дэлхийн эрүүл мэндийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх чиглэл бүхий 2023 оны 26 үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлэн 95 хувийн хэрэгжилттэй ажиллаа.*

Хамтран ажилласан байгууллага-210

Хэвтэн эмчлүүлэгч-4263

Төрийн албан хаагч -1100



Эмч, эмнэлгийн ажилтан - 1789

Өсвөр насныхан-9274

Бусад-12550



100 гаруй гарын авлага зөвлөмж, зурагт хуудсыг бэлтгэн 41696 хүнд түгээсэн.




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
# Тулгамдсан асуудал




**Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:**

- Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй арга хэмжээг хэрэгжүүлэх зохион байгуулалт БОЭТ, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвд хангалтгүй, эзэнжүүлэ эгүй, зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийг барьж ажиллахгүй, тайлагналт хангалтгүй

**Ахмад настны эрүүл мэндийн чиглэлээр:**

- Мэргэжлийн ахмадын эмч, сувилагч байхгүйгээс кабинетийн үйл ажиллагаа, настанд үзүүлэх тус ламж тусламж үйлчилгээ орхигдож байна
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ахмад настны эрүүл мэндийн цогц үнэлгээг бүрэн хийхгүй байна
- Тушаал, шийдвэрийн хэрэгжилт дутагдалтай

**Халдварт бус өвчний чиглэлээр:**

- Хүн амын дундах халдварт бус өвчлөлийн анхдагч эрсдэлт хүчин зүйл болох архи, тамхи, дасгал, хөдөлгөөнөөр хичээлэлдэг хүний эзлэх хувь бага байна.
- Хүн амын нас, хүйс, эрсдэлт суурилсан эрт илрүүлгийн үзлэгт хамрагдалт 18-аас дээш нас, ялангуяа 18-30 насанд бага, илрүүлсэн өвчлөлийг бүртгэж, эрүүлжүүлэх, хянах үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Халдварт бус өвчний эрт илрүүлгийг удирдамжийн дагуу хийхгүй байгаагаас үзлэг чанаргүй хийгдэж, өвчлөлийг илрүүлж чадахгүй байна.
- Халдварт бус өвчлөлийг хянах диспансерийн хяналт хангалтгүй, эмч илгээний үр дүнгийн хяналт байхгүй
- Орон нутгийн хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй хүчин зүйл /газар зүйн байршил, ундны ус, хоол хүнсний хэрэглээ, амьдралын хэв маяг/ -тай уялдуулан судлах, тандалт судалгаа хийдэггүй
- Сэргийлж болох өвчлөл, нас баралтад /амиа хорлолт, осол гэмтэл, санамсаргүйгээр хордох гм/ эрэгтэйчүүд илүү өртөж, сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна.




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
# Тулгамдсан асуудал




**Нөхөн үржихүйн эрүүл мэнд:**

- Эмэгтэйчүүдийн дундаж наслалтыг улсын дундажаас доогуур
- Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн хангалт, хүрэл цээ дутагдалтай
- Хүн амын өвчлөлийн эрүүлжүүлэлт дутагдалтай, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой эрүүл мэндийг хянах ад бэрхшээл үүсч байна.
- Цэргийн насны залуучуудын дундах өвчлөл өндөр байна.
- Өсвөр үеийнхний төрөлт, үр хөндөлт, амиа хорлолт тууштай буурахгүй байна
- Жендерийн талаарх удирдлага, эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг хомс, бодлого, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй

**Халдварт өвчний чиглэлээр:**

- БЗДХ, Сүрьеэгийн өвчлөлд өртөх эрсдэлт бүлгийг зөв тодорхойлж чадахгүй, бүртгэл мэдээлэл дутмаг байгаагаас урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдалт хангалтгүй байна.
- БЗДХ-ын эрсдэлт бүлгийг /эмэгтэй биеэ үнэлэгч, ЭБЭ, мансууруулах бодис судсаар хэрэглэгчид, / орон нутагт илрүүлж чадахгүй байна.
- Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээний бэлэн байдал хангалтгүй
- Дархлаажуулалтын хамралт зарим вакцин дээр буурч байна.

**Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын чиглэл ээр:**

- Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал, нөөц дутагдалтай
- Гамшгийн үед тусламж үйлчилгээ үзүүлэх арга барилд эмч, мэргэжилтнүүд суралцаагүй




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Тулгамдаж буй асуудал




**Орчны эрүүл мэндийн чиглэлээр:**
- Хүн амын ундны усны аюулгүй байдал
- Хөрс, агаарын бохирдол
- Эрүүл мэндийн байгууллагын ус, ариун цэврийн байгууламж
- Орчны бохирдлоос хүний эрүүл мэндийн нөлөөлөх нөлөөлөл

**Лабораторийн тусламж үйлчилгээний чиглэлээр:**
- Мэргэжлийн хүний нөөц дутагдалтай
- Тоног төхөөрөмжийг бүрэн ашиглахгүй байна. /урвалж оношлуур, тоног төхөөрөмж дээр ажиллаж чадахгүй/
- Багцад заасан зарим нэр төрлийн оношилгоо шинжилгээг хийхгүй байна.

**Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр:**
- Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоох судалгаа хийгдээгүй,
- Хүн амын өвчлөл, нас баралтад дүн шинжилгээ хийж, түүнийг бууруулах чиглэлээр систетэй ажил хийгдэхгүй
- Эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг бүх шатанд зөвхөн нийгмийн эрүүл мэндийн ажилтны ажил мэт ойлгодог
- Эрүүл мэндийн дэмжигч сум, байгууллага, айл өрх, хувь хүнийг дэмжих хөшүүрэг дутмаг




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
# Цаашдын зорилт, чиглэл




**Нөхөн үржихүйн эрүүл мэнд, өсвөр үе, эрэгтэйчүүдийн асуудал:**

- Эмэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн, эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, сэргийлж болох нас баралтыг бууруулах цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх
- Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн хэрэгцээг тодорхойлж, хангалтыг тендерийн хуулийн дагуу захиалж, нөөцийг бүрдүүлэн, тусламж үйлчилгээний тасалдалгүй байдлыг ханган ажиллах
- Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл, мэдээллийг шинэчлэн дүн шинжилгээ хийж, УБ болон бусад орон нутагт байгаа эмэгтэйчүүдийг тухайн газрынх нь эрүүл мэндийн байгууллагад бүртгүүлж, тусламж үйлчилгээг тасралтгүй авах боломжийг бүрдүүлэх
- Өвчлөлийг эрүүлжүүлэх ажлыг тухайн баг хариуцсан эмч мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, үр дүнгийн урамшуулалтай уялдуулах
- Цэргийн насны залуучуудын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй эрсдл ээс сэргийдэх мэдээлэл сургалт сурталчилгааг тасралтгүй зохион байгуулах, үр дүнг тооцох
- Өсвөр үеийнхэнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөв мэдлэг олгох ажлыг нотолгоонд тулгуурлан зохион байгуулах
- Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх тушаал шийдвэрийг эмч, мэргэжилтнүүд судлан ,орон нутагтаа хэрэгжүүлэх

**Ахмад настны эрүүл мэндийн чиглэлээр:**

- БОЭТ-д мэргэшсэн гериатрийн эмч, сувилагчийг бэлтгэж, ажиллуулах
- Гериатрийн кабинетыг стандартын дагуу тохижуулж, тоног төхөөрөмжөөр хангах
- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд ахмад настны эрүүл мэндийн цогц үнэлгээг тушаал зааврын дагуу бүрэн, чанартай хийх
- Тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавих

**Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын чиглэлээр:**

- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтмол сургаж чадавхижуулах
- Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211-р тушаалын дагуу болзошгүй гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед шаардагдах нөөцийн бэлэн байдлыг тогтмол хангах, шинэчлэх
- Арвайхээр суманд 100 ортой хээрийн эмнэлэг дэлгэх майхан асарыг шийдвэрлэх
- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, эрүүл мэндийн байгууллагуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжүүлж хэвших




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Цаашдын зорилт, чиглэл




**Халдварт өвчний чиглэлээр:**

- БЗДХ, Сүрьеэгийн өвчлөлд өртөх эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг ЭМС-ын 2024 оны тушаалд заасны дагуу шинэчлэн гаргаж, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах
- БЗДХ-ын эрсдэлт бүлэг /Эмэгтэй биеэ үнэлэгч, ЭБЭ, Мансууруулах бодис судсаар хэрэглэгчид/-тэй ажиллах төрийн бус байгууллагыг орон нутагт ажиллуулж, суралцах
- Халдварт өвчний эрт сэрэмжлүүлэг, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах
- Дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, хоцорсон хүүхдийг нэрээр хянаж, нөхөн дархлаажуулах
- Дархлаажуулалтын программ шинэчлэгдэж байгаатай холбоотой 2016 оноос хойших бүх хүүхдийн вакцины мэдээллийг эргэмжээр шивж оруулах асуудлах 5 сардаа багтаж, дуусгах
- Дархлаажуулалтын үйл ажиллагаанд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, хэрэгслийг кабинетэд байршуулж, ашиглалтад хяналт тавих

Салбар хоорондын хамтын ажиллагаа өрөгжүүлэх /*ЭМГ, ЗӨСТ, МЭ, ХХААГ, БОАЖГ, Сум өрхийн ЭМТ/.*

Тарваган тахал, боом өвчний голомттой сумдад анхааруулах пайз байршуулах

ЗХӨ-ний сэжигтэй тохиолдлыг ЭМС-ын 2017 Оны 508 Дугаар тушаалын дагуу ЗӨСТ-д мэдээлэх.

Сар бүрийн 03-ний дотор галзуугийн дархлаажуулалтын мэдээг ирүүлэх

ЭМС-ын 160 тоот тушаалын дагуу Тарваган тахал өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэн ажиллах




ЗХӨ-ний голомттой сумд дархлаажуулалтыг үр дүнтэй зохион байгуулах, бүх сумдууд галзуугийн сэжигтэй мал, чоно, нохойд уруулж шүлсдүүлсэн тохиолдол бүрийг вакцинжуулах /*уураглын зэрэг хүнд тохиолдлыг ийлдэс эмчилгээнд хамруулах*/

ЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа тогтмол зохион байгуулах

Голомтот нутагт хүн амын тандалт судалгаа хамтран зохион байгуулж, үр дүнг тооцон хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх




# Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ Цаашдын зорилт, чиглэл




**Орчны эрүүл мэндийн чиглэлээр:**

- Хүн амын ундны усны аюулгүй байдлыг хангах, шинжилгээг тогтмол хийлгэж, хариу арга хэмжээ авах /хими, физик, нян г.м /
- Салбар дундын мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг сайжруулах /тухайлбал орон нутгийн ногоон байгууламж, ургамлын онцлогын мэдээлэл, ус, хөрс, агаарын шинжилгээний дүн г.м/
- Уур амьдсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд нөлөөлөх судалгааг хийх, эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах
- Минимал хэрэглээг хэвшүүлэх /хүрээлэн буй орчин, эдийн засагт эерэгээр нөлөөлнө/

**Лабораторийн тусламж үйлчилгээний чиглэлээр:**

- Мэргэжлийн лабораторийн мэргэжилтнийг ажиллуулах, хүний нөөцийг чадавхижуулах
- “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж үйлчилгээний журам, жагсаалт, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай” ЭМС-ын А/283-р тушаал ын дагуу лабораторийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх
- Гадаад, дотоод хяналтад хамрагдах ажлыг тогтмолжуулах, үр дүнг тооцох

**Эрүүл мэндийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр:**

- Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг бууруулах ажлыг нотолгоонд тулгуурлан хийж, үр дүнг тооцох
- Тэргүүлж буй өвчлөл нас баралтыг бууруулахад чиглэсэн зорилтот арга хэмжээг сум бүрийн онцлогт тохирсон шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцох
- Эрүүл мэндийг бүрдүүлэгч нийгмийн сэтгэлзүйн соён гэгээрүүлэх ажиллагаанд бүх байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэнийг төлөвшүүлэх ажлыг салбар дундын оролцоотой гоор хэрэгжүүлэх
- Өвчлөлийг илрүүлэх, хянах, тандах, урьдчилан сэргийлэх, дэмжих үйл ажиллааг эмч, мэргэжилтэн бүрийн ажил үүрэгт тусгагдаж, хэрэгжүүлэх
- Эрүүл мэндийг дэмжигч сум, байгууллага, айл өрх, иргэнийг шалгаруулахад сум, орон нутгаас дэмжлэг, хөшүүрэг үзүүлэх




# Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024 “Хамгаалах нь Эмчлүүлэхээс чухал”




















Анхаарал хандуулсанд баярлалаа.




